**ТӨВ АЙМАГ ДАХЬ**

**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2025/02/НА-СТА-ОНА**

## БАРУУН ЗУУНМОД ББН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2025 он


Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Одбилэг

Утас: 70272287 Цахим хаяг: odbilegb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**............3
**Асуудлыг онцолсон хэсэг** .......... **Error! Bookmark not defined.**
**Аудитын гол асуудал** .......... **Error! Bookmark not defined.**
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН** ............5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ............5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан............6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан............7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан............7
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** .......... **Error! Bookmark not defined.**
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .......... **Error! Bookmark not defined.**
3.7 Судалгааны үр дүнгийн талаар .......... **Error! Bookmark not defined.**
**4.1 Ерөнхий зүйл** .......... **Error! Bookmark not defined.**
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** .......... **Error! Bookmark not defined.**
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ... **Error! Bookmark not defined.**
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт Error! Bookmark not defined.**
**4.5.1 Завсрын аудитын талаар** .......... **Error! Bookmark not defined.**
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** .......... **Error! Bookmark not defined.**
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ............8
5.1 Төлбөрийн акт ............9
**5.2 Албан шаардлага**............9
**5.3 Зөвлөмж**............9
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**............10

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УИХ | Улсын Их Хурал |
| НБББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| ӨЭМТ | Өрхийн эрүүл мэндийн төв |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tov@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/116

танай ______ -ны № ______ -т

БАРУУН ЗУУНМОД ББН ӨРХИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.ЭНХЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам"-ын дагуу тайлант онд Баруун Зуунмод ББН өрхийн эрүүл мэндийн төв нь 2 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Баруун Зуунмод ББН өрхийн эрүүл мэндийн төв нь 2024 онд 3 төрлийн эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг бүрэн үзүүлсний үр дүнд эрүүл мэндийн даатгалын сангаас 1,054,372.74 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа бүрэн зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/122 дугаар тушаалаар баталсан "Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах дуусгавар болгох журам"-ыг үндэслэн аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн

41250-237

газрын даргатай байгуулсан гурвалсан гэрээний 2024 оны гүйцэтгэлийн хэрэгжилт 90,5 хувь буюу “Бүрэн хангалттай” гэж дүгнэгдсэн байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **136,708,626.7** | **128,071,972.7** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 62,273.2 | 19,134.8 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 62,273.2 | 19,134.8 |
| **3121** | **Төгрөг** | 62,273.2 | 19,134.8 |
| 31217 | Төрийн сангийн харилцах - орон нутаг | 62,273.2 | 19,134.8 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 136,646,353.5 | 128,052,838.0 |
| **351** | **Түүхий эд материал** | 96,676,279.6 | 94,474,833.1 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 33,150,390.8 | 32,912,290.8 |
| 35130 | Эм боох материал | 63,525,888.8 | 61,562,542.2 |
| **354** | **Хангамжийн материал** | 39,970,074.0 | 33,578,004.9 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,197,344.0 | 7,300,964.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,594,454.4 | 9,368,910.0 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 325,600.0 | 446,600.0 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 8,916,225.6 | 5,260,010.9 |
| 35450 | Барилгын засварын материал | 10,841,950.0 | 9,300,060.0 |
| 35460 | Хүнсний материал | 946,000.0 | 71,460.0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 148,500.0 | 1,830,000.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **216,704,596.7** | **174,290,243.1** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 216,704,596.7 | 174,290,243.1 |
| **392** | **Биет хөрөнгө** | 212,642,420.1 | 170,404,066.6 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 165,575,524.0 | 165,575,524.0 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (54,111,785.7) | (60,714,903.7) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 28,880,000.0 | 28,880,000.0 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (19,209,482.6) | (23,914,583.2) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 208,026,963.0 | 210,396,563.0 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (139,570,117.6) | (171,853,401.9) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 48,355,965.0 | 51,510,765.0 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (25,304,646.0) | (29,475,896.6) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 4,062,176.6 | 3,886,176.5 |
| 39301 | Програм хангамж | 1,860,000.0 | 1,860,000.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,537,823.5) | (1,713,823.5) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,740,000.0 | 3,740,000.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **353,413,223.3** | **302,362,215.9** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **353,413,223.3** | **302,362,215.9** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 353,413,223.3 | 302,362,215.9 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 255,441,591.5 | 255,441,591.5 |
| 51101 | Өмч: - төрийн | 255,441,591.5 | 255,441,591.5 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 50,755,195.5 | (295,812.0) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 107,440,536.5 | 50,755,195.5 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (56,685,341.0) | (51,051,007.5) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 47,216,436.4 | 47,216,436.4 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **353,413,223.3** | **302,362,215.9** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,110,935,603.5** | **1,149,611,452.9** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,110,935,603.5** | **1,149,611,452.9** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 356,095,286.7 | 1,149,611,452.9 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 217,246,521.5 | 1,054,372,739.3 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 217,246,521.5 | 1,054,372,739.3 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 138,848,765.2 | 95,238,713.6 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,167,620,944.5** | **1,200,662,460.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,167,620,944.5** | **1,200,662,460.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,167,620,944.5 | 1,200,662,460.4 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,536,142.4 | 85,050,039.1 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,599,180.0 | 6,882,830.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,115,132.4 | 35,113,714.7 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,821,830.0 | 43,053,494.4 |
| **2105** | **Норматив зардал** | 169,691,498.2 | 138,663,173.1 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 159,188,598.2 | 136,475,673.1 |
| 210502 | Хоол, хүнс | 10,502,900.0 | 2,187,500.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,188,050.0 | 8,477,310.0 |
| 210604 | Урсгал засвар | 9,188,050.0 | 8,477,310.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 955,205,253.8 | 968,471,938.2 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 904,257,781.6 | 920,533,184.7 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 50,947,472.2 | 47,938,753.5 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(56,685,341.0)** | **(51,051,007.5)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(56,685,341.0)** | **(51,051,007.5)** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 255,441,591.5 | 47,216,436.4 | 107,440,536.5 | 410,098,564.3 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **255,441,591.5** | **47,216,436.4** | **107,440,536.5** | 410,098,564.3 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | -56,685,341.0 | -56,685,341.0 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **255,441,591.5** | **47,216,436.4** | **50,755,195.5** | 353,413,223.3 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **255,441,591.5** | **47,216,436.4** | **50,755,195.5** | 353,413,223.3 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **255,441,591.5** | **47,216,436.4** | **50,755,195.5** | 353,413,223.3 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | -51,051,007.5 | -51,051,007.5 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **255,441,591.5** | **47,216,436.4** | **-295,812.0** | 302,362,215.9 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **972,086,838.26** | **1,054,372,739.27** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **972,086,838.26** | **1,054,372,739.27** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 217,246,521.47 | 1,054,372,739.27 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 217,246,521.47 | 1,054,372,739.27 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 217,246,521.47 | 1,054,372,739.27 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,002,296,890.63** | **1,048,891,477.66** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,002,296,890.63** | **1,048,891,477.66** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,002,296,890.63** | **1,048,891,477.66** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,002,296,890.63 | 1,048,891,477.66 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,002,296,890.63 | 1,048,891,477.66 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(30,210,052.37)** | **5,481,261.61** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **28,530,000.00** | **5,524,400.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **28,530,000.00** | **5,524,400.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 28,530,000.00 | 5,524,400.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 28,530,000.00 | 5,524,400.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(28,530,000.00)** | **(5,524,400.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (58,740,052.37) | (43,138.39) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний** | 58,802,325.53 | 62,273.16 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 62,273.16 | 19,134.77 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 17,781.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12,521.6 мянган төгрөгийн алдааг залруулсан.

### 5.1 Залруулсан алдаа

- анхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг тулгаж үзэхэд мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 5,524.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийн дүнг салгаж тайлагнаагүй байна.
- Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг тулгаж үзэхэд санхүү байдлын тайлангийн бараа материалын дүн тодруулгатай 6,997.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,260.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,416.2 мянган төгрөгөөр бага тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

### 5.2 Залруулаагүй алдаа

Аудитаар нийт 5,260.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,260.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 3 зөрчилд зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

***Илрүүлэлт:*** Бараа материалын тайланд үлдэгдлээр тайлагнадсан 5,260.0 мянган төгрөгийн бензин талоны үлдэгдлийг баталгаажуулаагүй, тооцоо бодоогүй зөрчил байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ",12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1.Илрүүлэлт:*** Тус байгууллага нь бараа материалын тайланг гаргахдаа батлагдсан маягтын дагуу гаргаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг зөрчсөн байна.

***Өгсөн зөвлөмж:*** Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг дагаж мөрдөж, үйл ажиллагаандаа хэвшүүлэхийг зөвлөв.

***2.Илрүүлэлт:*** Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төв нь тайлант онд нийт 118,588.7 мянган төгрөгийн бараа материалыг холбогдох байгууллагуудтай гэрээ хийж шууд худалдан авалт хийсэн байна.

***Өгсөн зөвлөмж:*** Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг мөрдөн ажиллаж төсөвт өртгийн дээд хязгаарт хүрсэн бараа ажил үйлчилгээг холбогдох хууль, журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг зөвлөж байна.

***3.Илрүүлэлт:*** Баруун Зуунмод ББН Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа НББББ, программ хангамж нь байгууллагын онцлогт тохирохгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Иймд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа НББББ, программ хангамжийг байгууллагын онцлогт тохируулахыг зөвлөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. | 1 | | | | 1 | 5,260.0 | | |
| Батлагдсан маягтаар тайлан мэдээ гаргаагүй байна. | 3 | - | | | | | 3 | - |
| **Дүн** | **4** | | | | **1** | **5,260.0** | **3** | **-** |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn